



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/417

Мандалговь

“Сургуулийн барилгын засварын ажлын  
/Дундговь, Эрдэнэдалай сум/”-ын гүйцэтгэгчийг  
сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Сургуулийн барилгын засварын ажил /Дундговь, Эрдэнэдалай сум/”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Э.Чагнаадорж ( Газрын харилцаа, барилга хот  
байгуулалтын газрын дарга)

Гишүүд: Э.Хөхөөхүү (Иргэний төлөөлөл)

Х.Анхбаяр (Хот тохижуулах газрын дарга)

С.Алтантогос ( 3-р цэцэрлэгийн нярав)

Нарийн бичгийн дарга: М.Бат-Эрдэнэ (ОНӨГазрын ХАА хариуцсан  
мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Чагнаадорж)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060180